



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Талын зам ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/02/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт сум

2023 он

Миндүг Аудит ХХК

Гүйцэтгэх захирал С.Энхтөр

Утас: 95957791

Цахим хаяг: director@mindug.mn

Аудитын менежер Ц.Номингоо

Утас: 90098901

Цахим хаяг: soo@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	8
3.1 Байгууллага түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	11
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Материаллаг байдал	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
4.5.1 Завсрын аудитын талаар	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13
5.1 Төлбөрийн акт	13
5.3 Албан шаардлага	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

**ТАЛЫН ЗАМ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Б.ТҮВШИНМӨНХ ТАНАА**

2022.03.21 № 142

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Талын зам ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмч өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Талын зам ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын борлуулалтын орлого өмнө оноос 208,691.3 мянган төгрөг буюу 18 хувиар өссөн ба нийт борлуулалтын орлогод эзлэх нийт зардлыг 6 хувиар бууруулсан байна.

Аудитын гол асуудал

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 11-р сарын 18-ны өдрийн 01 тоот тогтоолоор 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг улсын чанартай зам засвар арчлалтын ажлыг гүйцэтгэн 861,900.0 мянган төгрөг, орон нутгийн зам засварын ажлыг гүйцэтгэн 215,000.0 мянган төгрөг нийт 1,076,900.0 мянган төгрөгийн орлого олохоор төлөвлөсөн байна. Нийт зардлыг 1,071,600.0 мянган төгрөгөөр баталж, ашигтай ажиллахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1,339,298.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,334,005.4 мянган төгрөгийн зардал гарч, 4,809.3 мянган төгрөгийн ашигтай ажилласныг санхүүгийн тайланд толилуулсан байна.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Бусад асуудлын хэсэг

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Үйл ажиллагааны тайлан, бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Үзүүлэлтийн нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.ХӨРӨНГӨ		
1.1.Эргэлтийн хөрөнгө		
1.1.1.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,733,883.57	3,583,305.95
1.1.2. Дансны авлага	151,648,997.21	158,979,593.80
1.1.6.Бара материал	210,673,737.51	469,985,101.78
1.1.11. Эргэлтйн хөрөнгийн дүн	364,056,618.28	632,548,001.52
1.2.1 Үндсэн хөрөнгө	930,811,674.14	941,592,258.17
1.2.2 Биет бус хөрөнгө	217,375,000.00	224,593,333.34
1.2.12 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,148,186,674.14	1,166,185,591.51
1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,512,243,292.42	1,798,733,593.03
2.1.1.1.Дансны өглөг	18,721,925.88	232,158,450.07
2.1.1.3 Татварын өр	84,887,350.48	152,593,813.01
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	103,609,276.37	384,752,263.08
2.1.2.4 Бусад урт хугацаат өр төлбөр	21,445,411.00	21,445,411.00
2.1.2.6 Урт хугацаат өр төлбөрийн дүн	21,445,411.00	21,445,411.00
2.2 Өр төлбөрийн нийт дүн	125,054,687.37	406,197,674.08
2.3 Эздийн өмч	1,148,115,089.34	1,148,653,112.82
2.3.1 Төрийн	1,148,115,089.34	1,148,653,112.82
2.3.6 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	242,135,306.17	242,135,306.17
2.3.8 Эздийн өмчийн бусад хэсэг	224,150,000.00	224,150,000.00
2.3.9 Хуримтлагдсан ашиг	(227,211,790.47)	(222,402,500.04)
2.3.11 Эздийн өмчийн дүн	1,387,188,605.04	1,392,535,918.95
2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,512,243,292.42	1,798,733,593.03

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1. Борлуулалтын орлого(Цэвэр орлого)	1,130,606,886.34	1,339,298,203.00
2.Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	909,492,995.63	1,000,471,005.53
Борлуулсан бараа бүтээгдэхүүний өртөг	75,707,816.87	124,773,681.21
Борлуулсан ажил, үйлчилгээний өртөг	833,785,178.76	875,697,324.32
3. Нийт ашиг (алдагдал)	221,113,890.71	338,827,197.47
8. Бусад орлого	27,667,272.73	42,524,779.96
9. Борлуулалт, маркетингийн зардал	82,361,138.79	216,268,441.72
10. Ерөнхий ба удирдлагын зардал	191,237,033.78	156,940,648.18
11. Санхүүгийн зардал	74,699.41	253,148.06
12. Бусад зардал	4,596,634.36	2,571,493.45
14. Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		25,410.00
18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(29,488,342.90)	5,343,656.03
19. Орлогын татварын зардал		534,365.60
20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	(29,488,342.90)	4,809,290.43
22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(29,488,342.90)	4,809,290.43
23. Бусад дэлгэрэнгүй орлого		
24. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	(29,488,342.90)	4,809,290.43
25. Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	1,148,115,089.34	242,135,306.17	224,150,000.00	(227,211,790.47)	1,387,188,605.04
3	Залруулсан үлдэгдэл					
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				4,809,290.43	4,809,290.43
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт	538,023.48				538,023.48
9	2023 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	1,148,653,112.82	242,135,306.17	224,150,000.00	(222,402,500.04)	1,392,535,918.95

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	1,201,201,709.45	1,640,921,077.62
1.1 Мөнгөн орлогын дүн	1,201,201,709.45	1,640,921,077.62
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	53,880,081.82	
Бусад мөнгөн орлого	1,147,321,627.63	1,640,921,077.62
1.2 Мөнгөн зарлагын дүн	1,255,471,552.51	1,636,151,655.24
Ажиллагчдад төлсөн	283,404,400.01	313,495,339.54
Нийгмийн даатгалын байгуулгад төлсөн	94,237,001.70	101,246,015.77
Бараа материал худалдан авахад төлсөн	768,528,238.81	1,093,647,088.45
Ашиглалтын зардал төлсөн	2,015,141.16	385,000.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	18,222,556.37	1,487,844.55
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгуулгад төлсөн	33,713,673.43	32,524,503.53
Даатгалын төлбөрт төлсөн		74,250.00
Бусад мөнгөн зарлага	55,350,541.03	93,291,613.40
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(54,269,843.06)	4,769,422.38
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	5,658,000.00	2,920,000.00
Мөнгөн орлогын дүн		-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Мөнгөн зарлагын дүн	5,658,000.00	2,920,000.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,658,000.00	2,920,000.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.20 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(5,658,000.00)	(2,920,000.00)
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(251,000.00)	
Мөнгөн орлогын дүн		-
Төрөл бүрийн хандив		
Мөнгөн зарлагын дүн	251,000.00	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(251,000.00)	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(60,178,843.06)	1,849,422.38
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	61,912,726.63	1,733,883.57
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,733,883.57	3,583,305.95
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага түүний үйл ажиллагаа

Талын зам ТӨХК-ийн зорилго нь хариуцсан А2001 Өндөрхаан Баруун-Урт чиглэлийн хатуу хучилттай автозамыг нүхэн эвдрэлгүй байлгах, тэмдэг тэмдэглэгээг бүрэн хийх гэсэн үндсэн зорилт оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг авто зам, засвар арчлалт гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд автозам, замын байгууламжийг засвар арчлалт статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх үүрэг бүхий замын салбарын засвар арчлалтын мэргэжлийн төрийн өмчит хувьцаат компани бөгөөд хөрөнгө оруулалтаар хийх ажлыг чанартай гүйцэтгэх гэсэн дэд зорилт дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй бөгөөд дотооддоо нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт боловсруулж мөрдөөгүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорилт гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө дунд зэрэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Талын зам ТӨХК нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага дотооддоо Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон бүртгэл хөтлөгдөхгүй байна.

Үйлдвэрлэлийн өртөг тооцох арга аргачлал боловсруулаагүйгээс санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийх, стратеги төлөвлөгөө боловсруулахад хүндрэл учрахаар байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт нэн даруй боловсруулан мөрдөж, нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сайжруулах хэрэгтэй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Сүхбаатар аймгийн Талын зам ТӨХК нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Компанийн өөрийн онцлог үйл ажиллагаанд тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлого байхгүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 382,169.2 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,733.9	3,583.3	1,849.4
Дансны авлага	151,649.0	158,979.6	7,330.6
Бараа материал	210,673.7	469,985.1	259,311.4
Үндсэн хөрөнгө	1,148,186.7	1,166,185.6	17,998.9
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,512,243.3	1,798,733.6	286,490.3
Богино хугацаат өр төлбөрийн дүн	103,609.3	384,752.3	281,143.0
Урт хугацаат өр төлбөрийн дүн	21,445.4	21,445.4	-
Өр төлбөрийн нийт дүн	125,054.7	406,197.7	281,143.0
Эздийн өмчийн дүн	1,387,188.6	1,392,535.9	5,347.3
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,512,243.3	1,798,733.6	286,490.3

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,849.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 488.3 мянган төгрөг касс бэлнээр, 3,155.0 мянган төгрөг харилцах дансанд үлдсэн байна.
- Дансны авлага 7,330.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба тайлант онд 1,666,356.5 мянган төгрөгийн авлага үүссэнээс 1,659,025.9 мянган төгрөгийн авлага төвлөрсөн. 2022 онд гүйцэтгэсэн ажлын 5 хувь үлдсэний улмаас авлага өссөн байна.
- Бараа материал данс 259,311.4 мянган төгрөгөөр өссөн нь Зогсоол-Амрах талбайн ажил, Эрдэнэцагаан сумын ариутгалын цэгийн суурийн ажил, Баруун-Урт сумын 1-р багийн нутагт 60 айлын хороолол дундах замын ажлын дуусаагүй үйлвэрлэл дансны үлдэгдэл нь дээрх өсөлтөд нөлөөлжээ.
- Үндсэн хөрөнгө данс 17,998.6 мянган төгрөгөөр өссөн нь 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдан худалдаж авсан асфальт бетоны индүү орлогод авсан, мөн ТӨБЗГ-ын 2022 оны 05-р сарын 16-ны өдрийн 933 тоот тогтоолоор 538.0 мянган төгрөгийн Пикап маркын автомашиныг балансаас балансад шилжүүлэн орлогод авсан, ТӨБЗГ-ын 2022 оны 12-р сарын 30-ны өдрийн

А-1/2641 тоот тогтоолоор 92,971.6 мянган төгрөгийн ашиглагдахгүй болсон машин тоног төхөөрөмж, тавилга эд хөрөнгийг акталж данснаас хасалт хийсэнтэй холбоотой өсөлт гарчээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Талын зам ТӨХК нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Талын зам ТӨХК нь техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 11-р сарын 18-ны өдрийн 07 тоот тогтоолоор батлуулжээ. Тайлант оны нийт орлогыг 1,076.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,060.3 сая төгрөгөөр, 14.9 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна. Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд өөрийн нөөц бололцоондоо тулгуурлан үндсэн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилго тавьжээ.

Өмнөх оны түвшинтэй харьцуулж үзэхэд 72.0 сая төгрөгөөр нэмж төлөвлөсөн бөгөөд ажилтнуудынхаа цалин хөлсийг нэмэгдүүлж, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд цалингийн фондыг 369.9 сая, нийгмийн даатгалын шимтгэл 96.2 сая, сэлбэгийн зардлыг 53.7 сая, ажилчдын мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах сургалтын зардал 5.8 сая, элэгдлийн зардлыг 123.6 сая, албан хэрэгцээний бичиг хэргийн зардлыг 3.0 сая, ашиглалтын зардлыг 9.1 сая, ажиллагсадтай холбоотой хөдөлмөр хамгааллын зардлыг 16.5 сая, түүхий эд материалын зардлыг 167.0 сая, шатах тослох материалын зардлыг 165.1 сая төгрөг, ТУЗ-н зардлыг 35.5 сая төгрөгөөр тус тус тооцсон байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр тухайн онд нөхөөсний индүү, шуурхай ажлын хэсгийн объектыг хашаажуулах, үндэсний архивын цахим санд 1982-2018 он хүртэлх байгууллагын архивын бичиг баримтыг оруулах, инженер техникийн ажилчдыг ажиллах нөхцөл боломжоор хангах зорилгоор зөөврийн компьютер, санхүүгийн бүртгэл тооцоог чанартай болгох зорилгоор нийт 63.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг тус тус төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр үйл ажиллагааны орлого нь 1,339.3 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 42.5 сая төгрөгийн орлого олсон ба үйлдвэрлэлийн нийт өртөг 1,000.5 сая, борлуулалт маркетингийн зардал 216.3 сая, ерөнхий удирдлагын зардал 156.9 сая төгрөг, санхүүгийн зардал болон бусад зардал 2.8 сая төгрөгийн тус тус зардалтай ажиллаж 5.3 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан. Татварын зардлыг 534.4 мянган төгрөг төлөхөөр тайланд тусгасан.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төлөвлөгөөний гүйцэтгэл 304,865.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн ба 28,3%-иар төлөвлөгөөнөөсөө өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь орон нутагт төлөвлөгөөнд тусгагдаагүй хайрган хучилттай авто замын ажил гүйцэтгэсэнтэй холбоотой нэмэлт орлогын үр дүн байна. Дуусаагүй үйлдвэрлэлийн зардлын 124,773.7 мянган төгрөг нь хуримтлагдсан элэгдлийн зардал бөгөөд 875,697.3 мянган төгрөгийн шууд материал, шууд хөдөлмөр, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал гарсан байна. Борлуулалтын орлого 28.3%-иар өссөн ба борлуулсан барааны өртөг болон нийт үйл ажиллагааны зардал өмнөх онтой харьцуулбал 18%-иар буурсан үр дүнтэй байна. Борлуулсан барааны өртөг өмнөх онтой харьцуулахад харимтлагдсан элэгдлийн зардлыг оруулахгүйгээр тооцвол 5%-иар буурсанд удирдлагын баг нь цаашид дүн шинжилгээ хийн ажиллах нь зөв юм.

Тайлант онд цэвэр ашиг 4,809.3 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 10,090.7 мянган төгрөгөөр дутуу байгаа нь тайлант хугацаанд төлөвлөгөөнд ороогүй тендерийн ажил гүйцэтгэсэн ба уг ажил 2023 онд дуусгавар болох юм.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Талын зам ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Миндүг аудит ХХК–ны аудитор Б.Бүзмаа, гүйцэтгэж, туслах аудитор Т.Цагаанбаяр, чанарын хяналтыг аудитор С.Энхтөр, хяналтыг Сүхбаатар аймаг дахь аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Талын зам ТӨХК нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Миндүг аудит ХХК –д 2023 оны 01 дүгээр сарын 25 -ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 13,642.4 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 9,549.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд уг зардлууд анхаарал татахуйц өсөлт байхгүй байна. НББ-ийн бодлогын бичиг баримт байхгүйгээс үйлдвэрлэсэн бараа, ажил үйлчилгээний өртгийн бүртгэл үзүүлэлт бүрээрээ стандартын дагуу бүртгэгдээгүй байдал ажиглагдсан ба өмнөх он болон тайланд онд дуусаагүй үйлдвэрлэлийн данс гэсэн ганцхан дансаар /шууд материал, шууд хөдөлмөр, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал данс нэг бүрээр үйлдвэрлэлийн өртөгийг бүртгээгүй/ үйлдвэрлэлийн зардлыг хуримтлуулан бүртгэсэн байгаа нь зардлын үзүүлэлт нэг бүрээр хэтрэлт хэмнэлт тооцох боломжгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант хугацаанд оруулбал зохих 169 мэдээллээс, хугацаандаа оруулсан 143 мэдээлэл хугацаандаа мэдээлэгдсэн байна. Хугацаа хоцорсон 26 мэдээлэл байна. Хугацаа хоцроосон нийт мэдээлэлд зөвхөн тоон үзүүлэлт ордог байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах зөвлөмж хүргүүлсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Сүхбаатар аймгийн Талын зам ТӨХК нь бусад хууль тогтоомжийн хүрээнд асуудалгүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай */бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/ нийцсэн* гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Талын зам ТӨХК 2022 онд завсрын аудит хийгээгүй

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Төлбөрийн актыг он дамжуулан 2023 онд төлж барагдуулсан байна

Хүснэгт 3 .Зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	-	1	-	100
Төлбөрийн акт	1	6,600.0			
Нийт дүн	2	6,600.0	1		50

Төлбөрийн актын авлагатай холбоотой бараа материалыг данснаас хасаж толилуулаагүй байна. Иймд санхүүгийн тайланг залруулж бүртгэх зөвлөмж өглөө.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Харилцагч байгууллагаас нэхэмжилсэн 71.3 сая төгрөгийн зам засварын асфалтийн төлбөрийг хуулийн байгууллагад шилжүүлсэн. Уг төлбөрийг хуулийн байгууллагын шийдвэрийг үндэслэн санхүүгийн тайланд тусгах шаардлага үүсэх учир, шүүхийн процесс дуусаагүй, дээд шатны шүүхэд шилжсэн байна. Иймд энэ асуудлыг дахин анхааралдаа авах нь зүйтэй юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 47.7 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 47.7 сая төгрөгийн алдааг залруулж залруулсан.

Нэмэгдсэн өртгийн албан татварын өглөгийг санхүүгийн тайланд 47,732.4 мянган төгрөг илүү тусгасаныг Татварын хэлтэст хүсэлт гарган засварлуулсан

Аудитаар нийт 45.1 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 44.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 44.5 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт.

Ажилтаны цалингаас 66.6 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл илүү суутгаж цалин дутуу олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Олон жил он дамнасан 27,571.3 мянган төгрөгийн авлага, ТӨБЗГ-аас акталж, сэлбэгээр худалдан борлуулах шийдвэр гарсан 2 автомашиныг бүртгэлээс хасаагүй бөгөөд сэлбэгийн орлого төвлөрсөн эсэх нь тодорхойгүй 16,916.0 мянган төгрөгийн хөрөнгийн зөрчлүүдэд 2 албан шаардлага өгсөн.

5.3 Зөвлөмж

5.3.1 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 36 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа нь НББОУС 8 "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үлдэх үнэ цэнийг санхүүгийн жил бүрийн эцэст дахин хянаж үзэх бөгөөд хэрэв эдгээрт өөрчлөлт орсон бол уг өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтөөр авч үзэж бүртгэнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн эдийн засгийн насжилт, ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, НББОУС-8 ийг мөрдөж ажиллах

5.3.2 Бараа материал данстай холбоотой асуудал.

Илрүүлэлт: Өмнөх оны аудитаар илэрсэн бараа материал дансанд байхгүй витумын тогоо данснаас хасч авлага үүсгээгүй.

Өгсөн зөвлөмж: НББ-ийн тухай хуулийн 5, 17 дугаар зүйлийн хүрээнд зарлуулах бичилт хийх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
НӨАТ-ын өглөг илүү бүртгэсэн	1	47,732.4			1	47,732.4	1	47,732.4				
Дүн	1	47,732.4			1	47,732.4	1	47,732.4				

